# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 06 сарын 27 өдөр Дугаар 289 Улаанбаатар хот

Баянхонгор аймгийн орон нутгийн өмчөөс 2025 онд хувьчлах эд хөрөнгийн жагсаалтыг зөвшилцөх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Баянхонгор аймгийн орон нутгийн өмчөөс 2025 онд хувьчлах эд хөрөнгийн жагсаалтыг хавсралт ёсоор дэмжсүгэй.

2. Тус барилгуудыг худалдах асуудлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу зохион байгуулж, дүнг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт танилцуулахыг Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчийн хуралд зөвлөмж болгосугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132001303

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 06 дугаар сарын 27-ны
өдрийн 179 дугаар тогтоолын хавсралт

БАЯНХОНГОР АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧӨӨС 2025 ОНД ХУВЬЧЛАХ ЭД ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| Д/д | Хувьчлах эд хөрөнгийн нэр | Эд хөрөнгийн олж авсан арга, хэлбэр, эрх зүйн акт, дугаар, огноо | Байршил | Хувьчлах эд хөрөнгийн үйл ажиллагааны чиглэл, үл хөдлөх хөрөнгийн зориулалт | Талбайн хэмжээ (м.кв) | Хувьчлах эд хөрөнгийн дүн (ААН бол нийт хөрөнгөөс өр төлбөр хассан дүнгээр, үл хөдлөх хөрөнгө бол балансын үлдэгдэл үнэ) (мян.төг) | Хувьчлах хугацаа | Хувьчлах арга, хэлбэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ингэний сүүний үйлдвэрийн барилга, тоног төхөөрөмж | Улсын төсвийн хөрөнгөөр | Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 9 дүгээр багт | Үйлдвэрлэлийн зориулалттай | 456м² | 3,848,147.305 | 2025 он | Уралдаант шалгаруулалтын аргаар |
| 2 | Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн эмчийн орон сууцны барилга | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын 1 дүгээр багт | Эмнэлгийн зориулалттай | 71,4м² | 12,701.700 | 2025 он | Нээлттэй дуудлагын худалдаа |
| 3 | Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын Конторын барилга | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын 6 дугаар багт | Төр, захиргааны зориулалттай | 1677,2м2 | 39,383.819 | 2025 он | Нээлттэй дуудлагын худалдаа |

....oOo..